



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/59/

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1. дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн "Осол, зөрчлийн талаарх мэдээллийг шуурхай дамжуулж ажиллах тухай" 30 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан "Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1 Журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т "..... мэдээллийг шууд хамаарах хэлтэс нь ангилан" гэсний дараа "холбогдох материалын хамт" гэж нэмсүгэй.

1.2 Журмын 1 дүгээр хавсралтын "Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Ерөнхий зохицуулагч инженер 976-11-281604" гэснийг "Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ерөнхий зохицуулагч инженер 976-11-281604" гэж, "Зам, тээврийн хөгжлийн яам 976-99994001" гэснийг "Зам, тээврийн хөгжлийн яам 976-99118095" гэж тус тус өөрчилсүгэй.

1.3 Журмын хавсралт 3-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар, харьяа алба салбар, иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /Б.Алтанцом/-д, Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба /С.Манлай/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН





ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

Аюулгүй ажиллагааны мэдээлэл
дамжуулах журам батлуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 30 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллага, орон нутгийн нисэх буудлууд болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхэлж байгаа бусад байгууллагуудын хооронд мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг зохицуулах "Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах журам"-ыг шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг иргэний нисэхийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын удирдлагуудад, мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга Б.Алтанцомд, Дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба /С.Манлай/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах журам батлуулах тухай" А/190 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА | Л.БЯМБАСҮРЭН

ХЯНАЛТТАЙ ХУВЬ
2018 -10- 22
ААЧБХ

08 3047

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журам нь Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид ИНЕГ гэх/, түүний харьяа албад, орон нутгийн нисэх буудлууд болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг сайжруулах, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой зөрчлийн талаарх мэдээллийг эх сурвалжаас цаг алдалгүй, үнэн зөв хүлээн авах, бүртгэх, холбогдох газар, албан тушаалтанд дамжуулах, шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах ажиллагаа

2.1 ИНЕГ-ын харьяа байгууллагууд болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагууд нь нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбогдолтой мэдээллийг цаг тухайд нь Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба /цаашид НААХЗА гэх/ хариуцлагатай жижүүр байцаагчийн 9898-5525 дугаарын утас, холбогдох маягт болон боломжтой бусад сувгуудыг ашиглан ИНЕГ-ын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл дамжуулах схем Хавсралт 1-ийн дагуу шуурхай мэдээлнэ.

2.2 Мэдээллийг ажлын бус цаг, амралтын өдрүүд, нийтээр амрах баярын өдрүүдэд холбогдох албан тушаалтанд суурин болон үүрэн телефон утас, цахим шуудан зэрэг аль боломжтой сувгаар шуурхай дамжуулна.

2.3 НААХЗА-ны хариуцлагатай жижүүрийн 9898-5525 дугаарын утсыг 7 хоногийн 1 дэх өдрийн 08 цагт дараагийн хэлтэст шилжүүлнэ.

2.4 НААХЗА-ны хариуцлагатай жижүүр нь нислэгийн болон үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг суурин болон үүрэн телефон утас, мессеж, цахим шуудан зэрэг аль боломжтой сувгаар дамжуулж байна.

Тайлбар: Энэ бүлэгт заасан "мэдээлэл" гэдгийг Нислэг-техникийн осол, зөрчил гарсан, байгалийн гамшиг, цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлын улмаас болон техникийн гэмтэл гарснаас агаарын хөлөг түр болон удаан хугацаагаар саатсан, нисэхийн аюулгүй байдалтай холбоотой, үйлдвэрлэлийн хэвийн бус үйл ажиллагаа, эрх бүхий байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хариуцлагагүй үйлдлээс шалтгаалан нислэг хойшилсон, тохиолдлыг ойлгоно.

Тайлбар: Энэ бүлэгт заасан "шуурхай" болон "нэн даруй" гэдгийг тухайн мэдээллийг хүлээн авснаас хойш 3-5 минутын дотор хугацаа гэж ойлгоно.

ХЯНАЛТТАЙ ХУВЬ
2018 -10- 22

Гурав. Мэдээллийн дагуу авах арга хэмжээ

3.1 НААХЗА-ны хариуцлагатай жижүүр байцаагч нь 9898-5525 дугаарын утсаар хүлээн авсан нислэгийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эсхүл нөлөөлж болзошгүй мэдээллийг Хавсралт 1-ийн дагуу Тэргүүн дэд дарга, Дэд дарга бөгөөд НААХЗА-ны дарга болон холбогдох хэлтсийн даргад нэн даруй дамжуулна. /хариуцлагатай жижүүрийн дэвтэрт мэдээллийг дэлгэрэнгүй бичиж тэмдэглэнэ/

3.2 Тэргүүн дэд дарга нь нислэгийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг Хавсралт 1-ийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яам / цаашид ЗТХЯ гэх/-ны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга болон ИНЕГ-ын даргад мэдээлнэ.

3.3 Тэргүүн дэд даргын эзгүйд хүлээн авсан мэдээллийг Хавсралт 1-ийн дагуу ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, ИНЕГ-ын даргад мэдээлнэ.

3.4 НААХЗА-ны хариуцлагатай жижүүрийн байцаагч нь мэдээллийг хүлээн авсан даруйдаа шаардлагатай тохиолдолд Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид НТОЗШША гэх/-д мэдээлнэ.

3.5 Мэдээлэл хүлээн авсан хэлтсийн дарга нь мэдээллийн агуулгаас шалтгаалан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг холбогдох нэгжтэй шууд болон хариуцлагатай жижүүр байцаагчаар дамжуулан авч хэрэгжүүлнэ.

3.6 Холбогдох хэлтсийн дарга нь мэдээллийн дагуу аюулгүй ажиллагааг хангахад оролцох ИНЕГ-ын болон бусад газар, албадын албан тушаалтанд Хавсралт 3-д заасан телефон утсаар тус тус дамжуулан, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг харилцан шуурхай авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Үүрэг

4.1 Иргэний нисэхийн ерөнхий газрын албан тушаалтан, ажилтан бүр нь нислэгийн аюулгүй ажиллагаа болой аюулгүй байдалтай холбоотой аливаа мэдээллийг НААХЗА-ны 98985525 дугаарын утас болон холбогдох маягтаар цаг тухайд нь шуурхай мэдээлнэ.

4.2 Утас, факс, цахим шуудангаар ирүүлсэн нислэгийн аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй байдалтай холбоотой зөрчлийн мэдээллийг шууд хамаарах хэлтэс нь ангилан, холбогдох материалын хамт Нислэгийн стандартын үйл ажиллагааны хяналтын хэлтэс / цаашид НСҮАХХ гэх/-д хүргүүлж НСҮАХХ нь зөрчлийг бүртгэх, цуглуулах үйл ажиллагааг хариуцна. Нууцлал бүхий мэдээллийг зохих эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэхээс өөрөөр бусдад дамжуулахыг хатуу хориглоно.

Тав. Хариуцлага

5.1 Нислэгийн осол, зөрчлийн талаар хүндэтгэх шалтгаангүй нуун дарагдуулсан болон мэдээлээгүй албан тушаалтан Иргэний нисэхийн тухай хууль болон Монгол улсын бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.




5.2 Нислэгийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг олон нийтэд "Аюулгүй ажиллагааны зөвлөл"-ийн шийдвэргүйгээр дамжуулах, мэдээлсэн тохиолдолд мөн хариуцлага хүлээнэ.

Зургаа. Мэдээллийг бүртгэх, тайлан гаргах


6.1 Энэ журмын Хавсралт 2-т тусгагдсан маягтын дагуу 7 хоногийн 5 дахь өдөр хариуцлагатай жижүүр байцаагчаар ажилласан байцаагч тайланг нэгтгэж хэлтсийн даргадаа танилцуулсан байна.

6.2 Хэлтсийн дарга нь 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө хариуцлагатай жижүүр байцаагчийн нэгтгэсэн тайланг хянаж НААХЗА-ны даргад хүргүүлсэн байна.



Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг холбооны хэрэгсэлээр дамжуулах схем

Хавсралт I



— НААХЗА-ны харилцаагаар дамжуулан мэдээлэх
 — Удирдлагын түвшинд шууд дамжуулах
 - - - - - Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллээр хангах
 - - - - - Тэргүүн дэд даргын эзгүйд мэдээлэл дамжуулах

ХЯНГАЛТ-АЙ ЖУВЬ
 2018 -10- 22
 ААЧБХ



Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт,
зохицуулалтын албаны аюулгүй ажиллагааны
мэдээллийн тайлан

Хавсралт 2

1	Албан тушаалтны нэр	Хэлтэс	Эхэлсэн огноо	
			Дууссан огноо	

2	Илэрсэн зөрчил, дутагдал			
---	--------------------------	--	--	--

Даваа:				
--------	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

Мягмар:				
---------	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

Лхагва:				
---------	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

Пүрэв:				
--------	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

Баасан:				
---------	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

3	Зөрчлийн дагуу авсан арга хэмжээ			
---	----------------------------------	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

--	--	--	--	--

4	Тайлан нэгтгэн гаргасан :	Хэлтсийн дарга:	/	/
---	---------------------------	-----------------	---	---

ХЯНАЛТТАЙ ХУВЬ
2018-10-22
АЛБА

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ АЛБАН ТУШААЛТНУУДАЙ
ХОЛБОГДОХ УТАСНЫ ЖАГСААЛТ

Хавсралт 3

Албан тушаал	Нэр	Утас	
		Ажил	Гар
ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс	Д.Мягмарсүрэн	-	976-99118095
НТОЗШША	-	-	976-95953399
ИНЕГ-ын дарга	Л.Бямбасүрэн	976-11-282001	976-99110240
Тэргүүн дэд дарга	Б.Алтанцом	976-11-282002	976-99113673
Дэд дарга бөгөөд НААХЗА-ны дарга	С.Манлай	976-11-285001	976-99110548
НААХЗА-ны менежер	Г.Ганхуяг	976-11-285112	976-99105588
НААХЗА-ны Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн дарга	М.Эрдэнэбатмөнх	976-11-285111	976-99115794
НААХЗА-ны Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн дарга	Б.Хүдэрчулуун	976-11-285009	976-94001299
НААХЗА-ны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн дарга	С.Ерханат	976-11-285004	976-88098188
НААХЗА-ны Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга	Д.Цогтсайхан	976-11-285003	976-99898988
"Чингис хаан" ОУНБ-ын Ерөнхий зохицуулагч	-	976-11-283047	-
НХУА-ны Ерөнхий нислэгийн удирдагчид	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлага	976-11-281618	-
	Ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлага	976-11-281611	-
ХНАА-ны Ерөнхий зохицуулагч инженер	-	976-11-281604	-
ЭХАТ мэдээлэл зохицуулах хэсэг	-	976-11-281691	-
		976-11-281622	

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

2018-10-22
ААЧБҮ

Иргэний нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээ эзэмшигчид	"МИАТ" ХК-ийн захирал Д.Баттөр	976-11-283077	976-99116227
	"Аэромонголиа" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Мөнхжаргал	976-11-283212	976-99994721
	"Хүннү эйр" ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Мөнхжаргал	976-11-283066	976-99112961 976-93112961
	"МАК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Нямжав	-	976-99094337
	"А-Жет Авизйшн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Нямбаяр	976-11-328769 976-11-281173	976-99119634
	"Геосан" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ	976-11-330438	976-99113613
	"Блю скай авизйшн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Даллас Дерксен	976-11-312085	976-99094920
	"Велталь Авиа Стар" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Өлзийсүрэн	-	976-95556278
	"Томас эйр" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Бүрэн-Эрдэнэ (ИНД-137)	-	976-96111459
	Топ Экстрим Экшин Монголиа ХХК-ийн Х-Тем Нисэх клубын гүйцэтгэх захирал А.Александр	-	976-99045965
	"Залуу бүргэд Женерал Авэйшн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Болдбаатар	-	976-99119128
	Ерөнхий зориулалтын-Хувийн	Иргэн Х.Бүрэн-Эрдэнэ (King Air С-90)	-
"Скай Такси" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Баттулга		-	976-99992902
"Аэрохэли" ХХК-		-	976-99110627

ХЯНАЛТАЙ ХУВЬ
2018 -10- 22
ААЧБХ

	ийн гүйцэтгэх захирал Б.Ганбат		
Орон нутгийн нисэх буудлууд	Нислэгийн мэдээллийн төвийн "Арцат"-976-11-281635, "Туул"-976-11-281637-с тухайн орон нутгийн нисэх буудлуудтай холбогдох утсыг лавлана.		

ХЯНАЛТТАЙ ХУВЬ
2018-10-22
2018 А.А.С.Б.Х